



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/87/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр

Утас: 89306788 Цахим хаяг:
otgonbayarde@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН ..	6
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	6
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/187
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.ЭНХТҮВШИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хантай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах хүрээнд байгууллагын үндсэн хөрөнгийг тоолж баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын тээвэр, шатахууны зардал өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь шар усны үерийн улмаас сумын төвийн айл өрх, албан байгууллага ундны усаа холоос тээвэрлэх, шар усны үерээс хамгаалах далан босгох зэрэг ажил хийгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газар нь 3 хөтөлбөр 9 арга хэмжээг хэрэгжүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 87.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,112,399.02	81,649,848.02
33	АВЛАГА	150,062.00	12,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,962,337.02	81,637,248.02
354	Хангамжийн материал	71,962,337.02	81,637,248.02
35410	Бичиг хэргийн материал	1,444,960.00	1,530,210.00
35420	Аж ахуйн материал	65,783,273.02	70,541,668.02
35440	Түлш, шатах тослох материал	4,640,104.00	9,387,370.00
35450	Барилгын засварын материал	94,000.00	178,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,565,250,394.43	1,496,562,374.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,565,250,394.43	1,496,562,374.86
392	Биет хөрөнгө	1,403,565,394.35	1,336,072,374.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	556,869,702.14	556,869,702.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72,231,995.16	-96,624,839.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	385,554,983.22	393,780,851.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57,890,749.25	-143,321,626.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,944,232.00	129,231,566.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,380,073.67	-50,007,109.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,514,114.00	22,264,114.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,425,381.57	-14,488,376.09
39209	Зам, гүүр байгууламж	417,902,312.50	417,902,312.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	-146,655,849.84	-169,229,324.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	355,044,273.83	410,156,172.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	-91,680,173.85	-120,461,067.11
393	Биет бус хөрөнгө	161,685,000.08	160,489,999.92
39301	Программ хангамж	4,572,000.00	4,572,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,196,999.92	-3,392,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	159,310,000.00	159,310,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,637,362,793.45	1,578,212,222.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,637,362,753.45	1,578,212,222.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,637,362,753.45	1,578,212,222.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	871,793,172.06	871,793,172.06
51101	Өмч: - төрийн	871,793,172.06	871,793,172.06
512	Хуримтлагдсан үр дүн	434,663,439.10	375,512,908.53
51210	Өмнөх үеийн үр дүн	434,663,439.10	434,663,439.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-59,150,530.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	330,906,142.29	330,906,142.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,637,362,793.45	1,578,212,222.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	779,402,826.00	744,066,941.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	304,962,356.00	145,547,441.00
120	Нийтлэг татварын бус орлого	304,962,356.00	145,547,441.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	304,962,356.00	145,547,441.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	304,962,356.00	145,547,441.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	474,440,470.00	598,519,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,757,770.00	46,897,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,745,770.00	26,627,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,012,000.00	20,270,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,682,700.00	551,622,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,682,700.00	551,622,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	578,905,227.64	802,598,225.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	578,905,227.64	802,598,225.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	560,870,070.64	700,551,181.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,832,185.00	280,123,746.00
210101	Үндсэн цалин	271,832,185.00	209,225,449.00
210102	Нэмэгдэл	00.00	58,664,538.00
210104	Урамшуулал	00.00	12,233,759.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,343,199.00	34,701,192.80
210201	Тэтгэврийн даатгал	24,349,443.00	24,118,720.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,718,322.00	2,801,238.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,174,656.00	2,240,990.00
210204	Ажилгүйдлийн даатгал	463,708.00	503,658.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,637,070.00	5,036,586.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,222,089.00	16,498,472.13
210301	Гэрэл, цахилгаан	1,766,810.00	3,331,338.13
210302	Түлш, халаалт	9,859,896.00	11,567,134.00
210303	Цэвэр, бохир ус	1,595,383.00	1,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,415,130.00	84,215,693.00
210401	Бичиг хэрэг	4,870,690.00	7,132,252.00
210402	Тээвэр, шатахуун	31,474,240.00	63,729,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,750,000.00	2,478,666.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	3,923,500.00	2100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,396,700.00	4,259,940.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,515,105.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,087,800.00	5,410,490.00
210604	Урсгал засвар	34,087,800.00	5,410,490.00
2107	Томилолт, зочны зардал	3,196,000.00	5,040,000.00
210702	Дотоод албан томилолт	3,196,000.00	5,040,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,885,526.00	28,182,373.00

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,862,830.00	26,765,250.00
210803	Даатгалын үйлчилгээ	264,200.00	264,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000.00	156,494.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	56,769.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	396,000.00	863,500.00
210807	Газрын төлбөр	82,496.00	76,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,888,141.64	246,379,214.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,401,390.00	22,990,700.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	734,500.00	1,186,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	116,752,251.64	222,202,514.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,035,157.00	102,047,044.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	87,726,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	1,280,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	27,433,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	55,798,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	3,214,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,199,037.00	14,320,544.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,199,037.00	14,320,544.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	200,497,598.36	-58,531,284.31
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	619,246.26
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	619,246.26
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-619,246.26
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	200,497,598.36	-59,150,530.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	477,944,052.00	598,519,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,944,052.00	598,519,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,261,352.00	46,897,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,745,770.00	26,627,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,515,582.00	20,270,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	451,682,700.00	551,622,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,682,700.00	551,622,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	473,844,152.00	585,213,200.00

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	473,844,152.00	585,213,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	451,470,395.00	483,166,155.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,832,185.00	280,366,313.08
210101	Үндсэн цалин	221,347,656.00	209,468,016.08
210102	Нэмэгдэл	50,484,529.00	58,664,538.00
210104	Үр дүнгийн урамшуулал		12,233,759.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,493,261.00	34,321,163.72
210201	Тэтгэврийн даатгал	23,601,761.00	23,970,818.05
210202	Тэтгэмжийн даатгал	2,722,900.00	2,712,768.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,178,300.00	2,060,370.16
210204	Ажилгүйдлийн даатгал	544,500.00	507,018.53
210205	Эрүүл мэндийн даатгал	5,445,800.00	5,070,188.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,362,193.00	21,245,738.13
210301	Гэрэл, цахилгаан	1,766,810.00	3,331,338.13
210302	Түлш, халаалт	10,000,000.00	16,314,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,595,383.00	1,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,559,340.00	79,551,588.00
210401	Бичиг хэрэг	5,131,500.00	6,352,542.00
210402	Тээвэр, шатахуун	31,474,240.00	63,729,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,750,000.00	2,478,666.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,923,500.00	2,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,280,100.00	4,890,650.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	2,600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	2,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,052,900.00	5,470,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	34,052,900.00	5,470,490.00
2107	Томилолт, зочны зардал	3,196,000.00	5,040,000.00
210702	Дотоод албан томилолт	3,196,000.00	5,040,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,741,106.00	30,394,163.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,718,410.00	28,977,040.00
210803	Даатгалын үйлчилгээ	264,200.00	264,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000.00	156,494.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	56,769.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	863,500.00
210807	Газрын төлбөр	82,496.00	76,160.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,733,410.00	24,176,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,998,910.00	22,990,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	734,500.00	1,186,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,373,757.00	102,047,044.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	87,726,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,280,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	27,433,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	55,798,800.00

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	3,214,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,199,037.00	14,320,544.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,199,037.00	14,320,544.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,099,900.00	13,306,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,099,900.00	13,306,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,099,900.00	13,306,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,099,900.00	13,306,300.00
223001	Бусад хөрөнгө	00.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,099,900.00	13,306,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,099,900.00	-13,306,300.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцоо нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,793,172.06	330,906,142.29	434,663,439.10	1,637,362,753.45
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,793,172.06	330,906,142.29	434,663,439.10	1,637,362,753.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	871,793,172.06	330,906,142.29	434,663,439.10	1,637,362,753.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-59,150,530.57	-59,150,530.57
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	871,793,172.06	330,906,142.29	375,512,908.53	1,578,212,222.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	551,622,500.0	542,466,935.9	9,155,564.1	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	551,622,500.0	542,466,935.9	9,155,564.1	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	467,090,500.0	457,954,935.9	9,135,564.1	98.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,814,000.0	280,366,313.1	4,447,686.9	98.4
210101	Үндсэн цалин	215,280,100.0	209,468,016.1	5,812,083.9	97.3
210102	Нэмэгдэл	61,700,000.00	58,664,538.00	3,035,862.00	95.1
210104	Үр дүнгийн урамшуулал	7,833,500.00	12,233,759.00	4,400,259.00	156.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,732,400.0	34,321,163.7	1,411,236.3	96.1
210201	Тэтгэврийн даатгал	24,905,100.0	23,970,818.1	934,281.9	156.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,706,900.0	2,712,768.6	-5,868.6	96.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,165,400.0	2,060,370.2	105,029.8	96.2
210204	Ажилгүйдлийн даатгал	541,300.0	507,018.5	34,281.5	100.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,413,700.0	5,070,188.4	343,511.6	93.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,250,400.0	21,245,738.1	4,661.9	100
210301	Гэрэл, цахилгаан	5,650,400.0	3,331,338.1	2,319,061.9	59
210302	Түлш, халаалт	14,000,000.0	16,314,400.0	-2,314,400.0	116.5
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.0	1,600,000.0	00.0	100
2104	Хангамж, бараа материалын зардал	53,593,600.0	53,496,158.0	97,442.0	99.8
210401	Бичиг хэрэг	5,800,000.0	5,799,542.0	458.0	100
210402	Тээвэр, шатахуун	38,227,300.0	38,227,300.0	00.0	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,413,000.0	2,478,666.0	-65,666.0	102.7
210404	Ном, хэвлэл	110,000.0	00.0	110,000.0	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,100,000.0	2,100,000.0	00.0	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,943,300.0	4,890,650.0	52,650.0	98.9
2105	Нормативт зардал	2,600,000.00	2,600,000.00		100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,600,000.00	2,600,000.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,778,200.0	18,776,790.0	1,410.0	100
210601	Багаж, техник хэрэгсэл	13,306,300.0	13,306,300.0	00.0	100
210604	Урсгал засвар	5,471,900.0	5,470,490.0	1,410.0	100
2107	Томилолт, зочны зардал	5,604,100.0	5,040,000.0	564,100.0	89.9
210702	Дотоод албан томилолт	5,604,100.0	5,040,000.0	564,100.0	89.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,517,800.0	17,932,073.0	2,585,727.0	87.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,909,600.0	16,514,950.0	2,394,650.0	87.3
210803	Даатгалын үйлчилгээ	264,200.0	264,200.0	00.0	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,000.0	156,494.0	506.0	99.7

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57,000.0	56,769.0	231.0	99.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	930,000.0	863,500.0	66,500.0	92.8
210807	Газрын төлбөр	200,000.0	76,160.0	123,840.0	38.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,200,000.0	24,176,700.0	23,300.0	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,000,000.0	22,990,700.0	9,300.0	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.0	1,186,000.00	14,000.0	98.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,532,000.0	84,512,000.0	20,000.0	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,532,000.0	84,512,000.0	20,000.0	98.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,300,000.0	1,280,000.00	20,000.0	100
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,433,200.0	27,433,200.00		100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,798,800.00	55,798,800.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	3,214,500.00	114,500	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	551,622,500.0	542,632,512.0	8,989,988.0	98.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	551,622,500.0	542,632,512.0	8,989,988.0	98.4
132001	Орон нутгийн төсвөөс	551,622,500.0	542,632,512.0	8,989,988.0	98.4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	00	00
620001	Удирдах ажилтан	09	09	00	00
620002	Гүйцэтгэх ажилтан	09	09	00	00
620003	Үйлчлэх ажилтан	08	08	00	00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,732,020.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,732,020.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,517,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,055,430.00
210402	Тээвэр, шатахуун	25,502,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,462,090.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,462,090.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,214,500.0

Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	3,214,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,214,500.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,732,020.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,732,020.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,462,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,270,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. 2022 онд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хоршоог хөгжүүлэх сангуудаас олгох зээлийг зөвхөн чанартай ажлын байрыг шинээр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, сумын бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын хэрэгцээгээ хангах зорилго бүхий Жижиг дунд хөдөлмөр эрхлэгчид болон шинээр Жижиг дунд хөдөлмөр эрхлэх чин хүсэлтэй иргэдэд олгож дэмжиж ажиллах.

2. Малын гаралтай түүхий эдийн зах зээлийг орон нутагтаа бий болгоно.

3. Газар тариалан, байгалийн ургамлын үйлдвэрлэлийг хөгжүүлж дотоодын нөөцөө бүрдүүлнэ.

4. Талх нарийн боов, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, биелэлтийг 100 хувиар дүгнүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 09 сарын 21 өдрийн А/17 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68,688.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	150.1	12.6	-137.4
Бараа материал	71,962.3	81,637.2	9,674.9
Үндсэн хөрөнгө	1,565,250.4	1,496,562.4	-68,688.0
Нийт хөрөнгө	1,637,362.8	1,578,212.2	-59,150.6
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,637,362.8	1,578,212.2	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,637,362.8	1,578,212.2	-59150.6

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө, өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн өмнөх оноос буурсан байна. Үүнд:

- Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлгүй байна.
- Бараа материал данс өмнөх оноос 9,674.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд түлш, шатах тослох материалын үнийн өсөлт болон шар усны үерийн хамгаалалтад зориулж аж ахуйн материалын худалдан авалт, зарцуулалт өссөнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө данс 68,688.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 154,133,741 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 222,202.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 522,835.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 28,787.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож 551,622.5 мянган төгрөгөөр баталсан байна. Орон нутгийн төсвөөс авах дүн нэмэгдсэн нь цалингийн үр дүнгийн урамшуулал болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Байгууллагын 2022 оны төсвийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны 12 тоот тогтоолоор баталсан ба ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 09 дугаар тогтоолоор 28,787.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 551,622.5 мянган орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 542,466.9 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 9,155.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 542,466.9 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлаас 5,812.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 2,620.5 мянган төгрөг, томилолт зочны зардал 564.1 мянган төгрөг, хангамжийн материалын зардлаас 97.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 36.8 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллаас 20.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/			
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101-үндсэн үйл ажиллагааны зардал	314,874.1	313,779.0	1,095.0	99.7%
2		80106-баг хорооны ҮАЗардал	69,182.4	63,791.4	5,390.9	92.2%
3		80112-нийтлэг үйлчилгээ	41,124.4	40,958.8	165.5	99.6%
4		80305-биеийн тамирын, уралдаан тэмцээн				
5		80802-ажил олгогчоос олгох тэтгэмж	57,098.8	56,998.8	100.0	99.8%
6		80815-сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	27,433.2	27,433.2	0	100%
7		81102-орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	14,990.7	9.3	99.9%
8		82801-улсын их баяр наадам	8,000.0	8,000.0		100%
9	71413-Байгаль орчинхамгаалах, нөхөн сэргээх	81701-Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	18,909.6	16,514.9	2,394.6	87.3%
	Нийт дүн		551,622.5	542,466.9	9,155.5	98.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тендерийн орлого 315.0 мянган төгрөг, спорт заал, ухаалаг худгийн орлого 9,250.6 мянган төгрөг, статистикийн хэлтсээс мал тооллогын зардал 4,796.8 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 300.0 мянган төгрөг, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 43.5 мянган төгрөг нийт 14,705.9 мянган төгрөгийн орлого орсон.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ахлах аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 451,682.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,775.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянахад 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож, 147 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 14,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хэрэгжилттэй холбоотой 400.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд зөвлөмжийг бүрэн биелүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	1	14,100.0	1	14,100.0	100
Зөвлөмж	1	400.0	1	400.0	100
Нийт дүн	2	14,500.0	2	14,500.0	

1.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудал гараагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:
АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР АХЛАХ АУДИТОР		Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 
БАТАЛГААЖУУЛСАН: АХЛАХ АУДИТОР		Б.ДАВААНЯМ ОГНОО: Д.ОТГОНБАЯР ОГНОО: 